



АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ШУУРХАЙ ЗӨВЛӨГӨӨНӨӨС ӨГӨГДСӨН ҮҮРЭГ ДААЛГАВРЫН ХЭРЭГЖИЛТ



2024 оны 11 дүгээр сарын 11-ний өдөр

ОРХОН АЙМГИЙН ЗАСАГ
ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР



1.Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг боловсруулах ажлын хэсгийг холбогдох мэргэжлийн төлөөллийг оролцуулан байгуулах.

Хугацаа: Ойрын хугацаанд





Биелэлт: ХШҮХ

Аймгийн Засаг даргын захирамжаар Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг боловсруулах ажлын хэсгийг аймгийн ЗДТГ-ын хэлтэс, агентлагийн удирдлагууд, Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ, Хүүхдийн оролцооны нэгдсэн төв, төр захиргааны байгууллагын ахмад ажилтан, эрдэмтэн судлаачдын төлөөллийг оролцуулан байгуулаад байна.

Хэрэгжилт: Хэрэгжиж байна.

ЧИЛЭМЭЛ - ДЭМЖЭГ



2. 2025 оны орон нутгийн төсөвт тусгах саналууд болон улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хийгдэх ажлын жагсаалтыг эрэмбэлж, Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэх.

Хугацаа: Ойрын хугацаанд






Биелэлт: ХБТХОХ

Орон нутгийн 2025 оны төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх 248 төсөл арга хэмжээний 120 гаруй тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий саналыг нэгтгэн 2024 оны 11 дүгээр сарын 08-ны өдөр Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлсэн.

Хэрэгжилт: Хэрэгжиж байна.





3. Аймгийг хөгжүүлэх таван жилийн Үндсэн чиглэлийг боловсруулах ажлын хэсгийг аймгийн ИТХ-д суудалтай намуудын төлөөллүүд болон бусад мэргэжлийн холбоодыг оролцуулан байгуулах.

Хугацаа: Ойрын хугацаанд





Биелэлт: ХБТХОХ

Аймгийг хөгжүүлэх таван жилийн Үндсэн чиглэлийг боловсруулах ажлын хэсгийг байгуулах захирамжийн төслийг боловсруулж байна.

Хэрэгжилт: Хэрэгжиж байна.





4. 7-р цэцэрлэгийн урд талын зогсоолын орц, гарц хийхэд шаардлагатай хөрөнгийг судалж танилцуулах.

Хугацаа: Ойрын хугацаанд





Биелэлт: ХЗА

7-р цэцэрлэгийн урд талын зогсоолын орц, гарц хийхэд шаардлагатай ажлын тоо хэмжээг гаргах ажил хийгдэж байна. Тус ажлын тоо хэмжээнд үндэслэн төсөв, хөрөнгийг тооцох ажил хийгдэнэ.

Хэрэгжилт: Хэрэгжиж байна.





5. Иргэдээс ирүүлсэн өргөдөл гомдол, санал, хүсэлт болон удирдлагуудаас өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилттэй газар дээр нь очиж танилцан, шийдвэрлэлтийн үр дүнг тогтмол мэдээлж ажиллах.

Хугацаа: Ойрын хугацаанд





Биелэлт: ТЗУХ

Санал хүсэлт хүлээн авах Засгийн газрын 11-11 төв, 70353511 утсаар ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтэд анхаарч ажиллахыг 38 төрийн байгууллагад мэдэгдсэн. Үүнд: Өргөдөл, гомдлын шийдвэрлэлт үнэн зөв байх, иргэнд хариу заавал мэдэгдэж хариу мэдэгдсэн талаарх мэдээллийг цахимд оруулах, шийдвэрлэх боломжгүй асуудлын шалтгаан, хуулийн үндэслэлийг иргэнд тайлбарлан цахимд оруулахыг мэдэгдэн хяналт тавин ажиллаж байна.

Мөн 70353511 утсанд иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлын талаарх мэдээллийг өдөр бүр аймгийн Засаг даргад танилцуулан ажиллаж байна.

Хэрэгжилт: Хэрэгжиж байна.



АНХААРАЛ ХАНДУУЛСАНД БАЯРЛАЛАА

2024 он

НАЙРАМДАЛ - ДРЧУЖДА

